

ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР
ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ АЖЛЫН
ЗӨВЛӨМЖ

2023.01.09

Дугаар 2023/01

Улаанбаатар хот

“Дүүргийн засаг даргын дэргэдэх байгууллагуудын
2022 оны үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүнгийн тухай”

Дүүргийн Засаг даргын 2022 оны “Хан-Уул дүүргийн засаг захиргааны нэгж, харьяа байгууллагуудын 2022 оны үйл ажиллагааны үр дүнд хяналт-шинжилгээ үнэлгээ хийх тухай” А/555 дугаар захирамжаар батлагдсан удирдамжийн дагуу дэргэдэх байгууллагуудын үйл ажиллагааны үр дүнг үнэлэх ажлыг хийсэн.

Үнэлгээний ажлыг гүйцэтгэхдээ Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам” болон бусад холбогдох эрх зүйн актуудыг удирдлага болгосон.

Ажлын хэсгээс дэргэдэх хэлтэс албадын 2022 оны үйл ажиллагаанд “Бүрэн хангалттай”, “Хангалттай”, “Ажил сайжруулах шаардлагатай” гэсэн үнэлгээ өгч, танай байгууллагын үйл ажиллагаанд анхаарах дараах зөвлөмжийг хүргүүлж байна.

НЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ХҮРЭЭНД

1. Бодлогын баримт бичиг, Тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг мэдээлэхдээ тодорхой, хэмжигдэхүйц байдлаар тайлагнаж, гүйцэтгэлийн хувь, үнэлгээг холбогдох журмыг баримтлан бодит байдлаар тооцох; /Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журмыг мөрдөх/
2. Үүрэг даалгаврын биелэлтэд өмнө нь хэрэгжүүлсэн ажил бус тухайн шуурхай зөвлөгөөнөөс хойш хэрэгжүүлсэн арга хэмжээ болон шийдвэр үр дүнд хүрсэн эсэхийг тоо, чанарын үзүүлэлттэй үнэн, зөв нягтлан тусгаж, эрх бүхий албан тушаалтнаар хянуулж, баталгаажуулж ирүүлэхийн зэрэгцээ шаардлагатай бол нотлох баримтыг файлаар хавсаргах;
3. Тайлант хугацааны гүйцэтгэлийг бүрэн хамруулж, үг үсгийн болон хэл найруулгын алдаагүй, тоо баримт зөрүүгүй, 2000 (хоёр мянган) тэмдэгтэд багтаан Засгийн газрын 2020 оны 246 дугаар тогтоолоор батлагдсан Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журмын 6.3.4.3; 6.3.4.4; 6.3.4.5; 6.3.5.4 дэх заалтыг мөрдөж тайлагнасан байх;

4. Бодлогын баримт бичигт заасан тухайн арга хэмжээнд батлагдсан төсвөөс гадна бусад эх үүсвэрээс шууд бус хамааралтайгаар хэрэгжсэн холбогдох төсөл арга хэмжээний талаарх мэдээллийг бүрэн судалж, тусгах;

5. Дүүргийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний 2022 оны төлөвлөгөөнөөс биелэлт хангалтгүй зарим арга хэмжээний хэрэгжилтийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд анхаарч, байгууллага, нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж, хэрэгжилтийг хангах;

Үр дүнгүй 2 арга хэмжээ:

№	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин
---	------------------	-------------	---------------------------------	--------------	-----------------	---------------

НЭГ. ЭКО ДҮҮРЭГ – НОГООН ХӨГЖИЛ

1.3 Хүнс, хөдөө аж ахуй, инноваци

1.3.3 Орчин үеийн дэвшилтэт технологи бүхий бага, дунд оврын жишиг загвар бүхий үйлдвэр байгуулахыг дэмжиж, үйлдвэрлэл эрхлэгчдийн үйл ажиллагааг олон нийтэд таниулан сурталчилна.

20	Инкубатор төвийн барилгын гүйцэтгэлийн хувь	хувь	ЖДҮДТ, ТГУХ	-	10	0
----	---	------	-------------	---	----	---

ХОЁР. ЭРҮҮЛ ДҮҮРЭГ – ХҮНИЙ ХӨГЖИЛ

2.2. Эрүүл мэнд

2.2.4. Эх хүүхдэд үзүүлэх тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, чанарыг сайжруулна.

42	0-1, 1-5 хүртэлх насны хүүхдийн 1,000 амьд төрөлтөд ногдох эндэгдлийн түвшин	тоо	НХХ, ЭМТ, ХУДНЭ	6.2	6.4	10,2
----	--	-----	-----------------	-----	-----	------

Эрчимжүүлэх шаардлагатай 7 арга хэмжээ:

№	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин
---	------------------	-------------	---------------------------------	--------------	-----------------	---------------

НЭГ. ЭКО ДҮҮРЭГ – НОГООН ХӨГЖИЛ

1.2. Агаарын бохирдол

1.2.2 Төрийн өмчийн халаалтын зуухнуудыг үе шаттайгаар төвлөрсөн дулаанд холбоно.

9	Төвлөрсөн дулаанд холбогдоогүй халаалтын зуухны тоо	тоо	ХХҮХ, ЖДҮДТ	-	4-5	1
---	---	-----	-------------	---	-----	---

ХОЁР. ЭРҮҮЛ ДҮҮРЭГ – ХҮНИЙ ХӨГЖИЛ

2.2. Эрүүл мэнд

2.2.3 Дүүргийн Эрүүл мэндийн төвд эрэгтэйчүүдийн кабинет байгуулна.

40	Байгуулсан эрэгтэйчүүдийн кабинетын тоо	тоо	НБХ, ЭМТ, ХУДНЭ	0	1	0
----	---	-----	-----------------	---	---	---

ДӨРӨВ. НИЙГМИЙН ХӨГЖИЛ - ӨРХ БҮРТ

4.5. Гэр бүл

4.5.1 Дэлхийн гэр бүлийн өдрийг тохиолдуулан Төрөлт, гэрлэлтийн бүртгэлийг ёслолтой бүртгэх

109	Дэлхийн гэр бүлийн өдрийг тохиолдуулан 100 иргэний "Төрөлт, гэрлэлтийн бүртгэл"-ийг ёслолтой бүртгэх	тоо	НБХ, СО, ГБХЗХХ	2	100	46
-----	--	-----	-----------------	---	-----	----

4.5.4 Залуучуудын хөгжлийг дэмжих, нийгмийн идэвх, оролцоог нэмэгдүүлэх зорилгоор "Залуучуудын хөгжил" дэд хөтөлбөр хэрэгжүүлнэ.

111	Чуулга уулзалтад оролцох залуучууд	тоо	НХХ, БХ	500	500	157
-----	------------------------------------	-----	---------	-----	-----	-----

4.5.6 "Архигүй орчин" дэд хөтөлбөрийн хэрэгжилт

114	"Архигүй орчин" дэд хөтөлбөрийн хэрэгжилт	хувь	ТЗУХ, ГБХЗХХ, ЦГ, ЭМТ	20	50	50
-----	---	------	-----------------------	----	----	----

4.5.8 Жендэрийн эрх тэгш байдлыг хангах дэд хөтөлбөр боловсруулж, үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

117	Жендэрийн тэгш байдлыг хангах дэд хөтөлбөрийн хэрэгжилт	хувь	НБХ, ГБХЗХХ	20	50	50
-----	---	------	-------------	----	----	----

ТАВ. ДЭД БҮТЦИЙН ХӨГЖИЛ - ХОРОО БҮРТ

5.1 Газрын харилцаа

5.1.1. Хот байгуулалтын кадастрын мэдээллийн санг Улсын хаягийн нэгдсэн системтэй холбож, хаягжилтын нэгдсэн стандартад шилжүүлэх ажлыг талуудтай хамтран дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулна.

119	Дүүргийн нутаг дэвсгэрт байгаа цэг тэмдэгт бүртгэлжүүлж, эзэнжүүлсэн байдал	хувь	ГЗБА	102 ширхэг цэг тэмдэгт хариуцах эзэнгүй байна	30	10
-----	---	------	------	---	----	----

6. Төсөв шаардагдахгүй хэрэгжүүлэх боломжтой арга хэмжээнүүдийг идэвх санаачилга гарган нөөц бололцоогоо дайчилж биелэлтийг хангаж ажиллах,

7. Нэгжийн задгай, бичвэр тайлангаас өдөр тутмын үйл ажиллагааны хэрэгжилтийг шууд хуулалгүй, төлөвлөсөн арга хэмжээ, зорилго, хүрэх түвшинд хамаарах бодлогын чанартай үйл ажиллагааны үр дүнг товч тодорхой тайлагнах шаардлагатай.

ХОЁР. БАЙГУУЛЛАГЫН ЧИГ ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ХҮРЭЭНД

6. Дүүргийн Засаг даргатай байгуулсан хариуцлагын гэрээний биелэлтийг Засгийн газрын 2022 оны 374 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралт, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө, тайланг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын

2020 оны 100 дугаар тушаалын 4, 7 дугаар хавсралтын дагуу тус тус боловсруулж хугацаанд нь тайлагнаж хэвших;

7. Хяналт, шалгалтын байгууллагаас өгсөн зөвлөмж, актын хэрэгжилтийг мэдээлэхдээ тодорхой, тоо, чанарын үзүүлэлтээр тайлагнаж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг тусган эрх бүхий албан тушаалтнаар хянуулж, баталгаажуулж, цахимаар тайлагнаж байгаа тохиолдолд цаасан дээр буулгаж архивлах;

8. Дүүргийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ, үнэлгээний ажлын хэсгээс өгсөн зөвлөмжийн дагуу төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэн хагас бүтэн жилээр биелэлтийг тооцож, хугацаанд нь тайлагнах;

9. Монгол Улсын Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Засгийн газрын 2020 оны 246 дугаар тогтоолоор батлагдсан Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журмын хэрэгжилтийг хангаж, албан хаагчдын баримт бичиг боловсруулах чадавхийг сайжруулахад анхаарч ажиллах хэрэгтэй.

ГУРАВ. БАЙГУУЛЛАГЫН НЭЭЛТТЭЙ БАЙДЛЫН ХҮРЭЭНД

10. Дүүргийн Засаг даргын 2022 онд баталсан хуваарийн дагуу Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан хориглосноос бусад мэдээллийг дүүргийн болон байгууллагын цахим хуудсанд хуулийн хугацаанд байршуулах;

11. Дүүргийн цахим хуудсанд байгууллагын үйлчилгээний нэр төрөл, шийдвэрлэх журам, хугацаа, бүрдүүлэх баримт бичиг, түүний загвар, төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ, төлбөр төлөх дансны мэдээллийг тухай бүр шинэчилж байршуулж хэвших;

12. Орон нутгийн өмчит байгууллагууд улсын төсвийн хөрөнгөөр болон гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт явцыг цахим хуудсандаа тухай бүр байршуулж, баяжилт, шинэчлэлт хийх;

13. Байгууллагын албан ёсны цахим хуудсаа Хан-Уул дүүргийн албан ёсны www.khanuul.mn цахим хуудастай холбож, мэдээллийн баяжилтыг тогтмол хийж, иргэдэд мэдээллийг нээлттэй болгох чиглэлээр бүх сурвалжийг ашиглах нь үр дүнтэй.

ДӨРӨВ. ЗАСГИЙН ГАЗРЫН ТЭРГҮҮЛЭХ АЧ ХОЛБОГДОЛТОЙ БОДЛОГЫН ХҮРЭЭНД

14. Төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус төр, хувийн хэвшил, хамт олны хүрээнд тарьсан бүх мод, бут, сөөгний арчлалт, хамгаалалт, ургалтын явцыг анхаарч, хянан үр дүнг тооцох;

15. Байгууллагын хэмжээнд хог хаягдлын менежментийг сайжруулах чиглэлээр үр дүнтэй арга, туршлага нэвтрүүлж, хэвшил болгох;

16. Байгууллагад ирсэн өргөдөл, гомдлын төрөл, тоог бууруулах, шийдвэрлэлтэд онцгой анхаарч, удаа дараа зөрчил тооцуулсан албан тушаалтан, албан хаагчдад холбогдох хуульд заасан хариуцлагыг тооцож, зөрчилгүй ажиллах;

17. Ирсэн явсан албан бичгийг холбогдох журмын дагуу хөтөлж, хариутай болон хариугүй албан бичгийг хуулийн хугацаанд зөрчилгүй шийдвэрлэх, удаа дараа зөрчил тооцуулсан албан тушаалтан, албан хаагчдад холбогдох хуульд заасан хариуцлагыг тооцож, EDOC системд зөрчил тооцуулахгүй ажиллах;

18. E-mongolia цахим систем хэрэглэгч байгууллагууд тухайн салбар, нэгжийн үйлчилгээний төрөл, үр дүнг цахим хуудсандаа байршуулж, үр дүнг тооцож ажиллах нь зүйтэй.

ЗӨВЛӨМЖТЭЙ ТАНИЛЦСАН:

С.ЭНХБАЯР

Засаг даргын Тамгын газрын дарга

ЗӨВЛӨМЖ ХЯНАСАН:

Л.ОТГОНБАЯР

Төлөвлөлт, гүйцэтгэлийн удирдлагын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

ЗӨВЛӨМЖ БОЛОВСРУУЛСАН:

Н.АЛДАРМАА

Хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн